

ЗӨВЛӨМЖ
/УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ/

2003 оны 11 дүгээр сар

Зарим төсвийн байгууллагаас иргэний хэрэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжийн талаар зарим зүйлийг тодруулахыг хүссэн хүсэлтүүд ирж байгаатай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас дараахи зөвлөмжийг өгч байна.

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “...Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлж нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагчаар төлүүлэн нэхэмжлэгчид буцаан олгоно. Улсын тэмдэгтийн хураамжийг энэ хуульд заасны дагуу төлнө” гэж заасан нь төсвийн байгууллага хариуцагчаар оролцсон иргэний хэрэгт хэрэв нэхэмжлэл нь ямар нэг хэмжээгээр хангагдсан тохиолдолд нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжинд урьдчилан төлсөн мөнгийг уг төсвийн байгууллагаар төлүүлж, нэхэмжлэгчид буцаан олгоно.

2. Харин төсвийн байгууллага давж заалдах, буюу хяналтын журмаар гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэхгүй. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4, 173 дугаар зүйлийн 173.3-т “...гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1-д заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ” гэж заасан бөгөөд уг 57 дугаар зүйлийн 57.1 заалт нь анх нэхэмжлэл гаргахад тэмдэгтийн хураамжийг төлүүлэхтэй адил агуулгаар тусгагдсан билээ. Иймд Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт төсвийн байгууллагын нэхэмжлэл хураамжаас чөлөөлөгдөхөөр заасны дагуу төсвийн байгууллагын нэхэмжлэл, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө гэж ойлгоно.

3. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ улсын тэмдэгтийн хураамжийг дараахи байдлаар хуваарилан төлүүлж байх зүйтэй.

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол нэхэмжлэгчийн төлсөн тэмдэгтийн хураамжийн 50 хувийг улсын төсвөөс буцаан гаргуулна.
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, мөн нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн бол хариуцагчаас тэмдэгтийн хураамжийн 50 хувийг гаргуулж нэхэмжлэгчид, мөн улсын төсвөөс нэхэмжлэгчийн төлсөн тэмдэгтийн хураамжийн 50 хувийг гаргуулж нэхэмжлэгчид.
- Зохигчид эвлэрсэн бол:
 - Эвлэрлийн гэрээндээ тэмдэгтийн хураамжийг хэрхэн хуваарилахыг тусгасан бол гэрээнд зааснаар.
 - Гэрээнд тусгаагүй бол улсын төсвөөс нэхэмжлэгчийн тэмдэгтийн хураамжинд төлсөн мөнгөний 50 хувийг буцаан гаргуулж, мөн үлдэх 50 хувийг төлөх талаар зохигчид тохиролцож чадахгүй бол тэдгээрийн эвлэрэн хэлэлцсэн нэхэмжлэлийн үнийн дүнг харгалзан шүүх хуваарилан хариуцагчид оногдох хэсгийн тал хувийг гаргуулж нэхэмжлэгчид олгоно.

Монгол Улсын Их хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн баталж, мөрдсөнтэй холбоотойгоор энэхүү харилцааг зохицуулсан хуульд зохих өөрчлөлт орох хүртэл дээрхи журмаар асуудлыг зохицуулж байх нь зүйтэй гэж манай Танхимаас үзэж байгаа болно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ